MERIT төслийн мэдээ

2019 оны 1-р сар | Сэтгүүл № 3

Уул уурхай ба байгаль орчны хяналтад газар зүйн мэдээллийн системийг ашиглах нь

2018 оны 10-р сарын 21-нээс 11-р сарын 05

MERIT төсөл аймаг, сумдын түвшинд уул уурхай, байгаль орчны хяналт, газар ашиглалтын менежментийн асуудал хариуцдаг орон нутгийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгууллаа.

Уг сургалтаар газрын зургийг дижитал хэлбэрээр ашиглаж болох программ хангамжийн суурь онол, ойлголт, арга техникийг заахын зэрэгцээ оролцогчдод уурхайд хяналт тавих, байгаль орчны үнэлгээ хийх өдөр тутмын ажилдаа “газарзүйн мэдээллийн систем” (ГМС)-ийг ашиглах мэдлэг чадвар, аргачлалд сургасан.



Техникийн зөвлөх Аугусто Риберо ГМС-ийн сургалтыг Дорнод, Сүхбаатар аймгийн албан хаагчдыг оролцуулан Дорнод аймагт хүргэв

MERIT, ШУТИС, Дорнод их сургууль ЖДҮ-үүдэд зориулсан сургалт зохион байгуулахаар хамтран ажиллаж байна

2018 оны 10-р сарын 24-нээс 11-р сарын 11

Дорнодын ЖДҮ эрхлэгчид өөрийн орон нутаг дахь уул уурхайн компаниудад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэхэд шаардлагатай бизнесийн ур чадварыг нь хөгжүүлэх үүднээс MERIT төсөл ШУТИС болон Дорнод их сургуультай хамтран ажиллаж, сургалтын хөтөлбөр боловсруулав.

Сургалтын хөтөлбөрт анхан шатны данс тооцоо хөтлөлт, санхүүжилт олж авахын тулд бизнес төлөвлөгөө бичих зэрэг бизнесийн үндсэн ур чадвар олгох сэдвүүд багтжээ.



Техникийн зөвлөх Эрик Карлзин ШУТИС-ийн оролцогчдын хамт

Байгаль орчны хяналт шалгалтыг бэхжүүлэх нь

2018 оны 10-р сарын 25—26

Олборлох салбараас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хянах төрийн хяналт шалгалтыг бэхжүүлэхийн тулд MERIT төсөл, Байгаль орчин, аялал жуулчлалын яам ба Газарзүй-геоэкологийн хүрээлэнтэй хамтран 10 дугаар сард Төв аймгийн Зуунмод хотноо “Газрын доройтол, цөлжилт” сэдвээр сургалт явууллаа.

Сургалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 онд зохион байгуулах үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрийг боловсруулахад суурь болгон ашиглах юм.



АМГТГ болон Дорнод аймгийн Засаг даргын тамгын газарт хүний нөөцийн ур чадварын сургалт явуулав

2018 оны 10-р сарын 24-нээс 11-р сарын 11

MERIT төслийн зүгээс Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) болон Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын ажиллагсдад Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоог бий болгох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа билээ.

Уг тогтолцоо нь ур чадвар, SMART зорилго болон Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (ГШҮ)-ийг тусгах замаар ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан сайжруулах талаар сургалт явуулж, ментор хийх замаар мэргэжлийн, ур дүнтэй, өндөр бүтээмжтэй ажиллах хүчинг хөгжүүлэхэд дэмжлэг болгох үүднээс боловсруулан гаргасан.

Газарзүй-геоэкологийн хүрээлэн дэх жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах нь

2018 оны 10-р сарын 25

Газарзүй-геоэкологийн хүрээлэнд томилогдож ажиллаж буй MERIT төслийн урт хугацааны зөвлөх Миша Гофорт нь тус хүрээлэнгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллаж жендэрийн талаарх танилцуулга сургалтыг зохион байгууллаа.

Сургалт жендэрийн тэгш байдлыг хангах, байгууллагын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ялангуяа ШУТИМ (шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик)-ийн салбар болон Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн судалгаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах талаар мэдлэг чадвар, үндсэн ур чадвар олгох зорилготой юм.

> Сургалтын дараа би жендэрийн багт орохоор шийдсэн. Бид эдгээр асуудлыг сайн ойлгосон тул бусдыг сургахад өөрийн ур чадвар, зүрх сэтгэлээ зориулж, эерэг үр дүн авчирч чадна гэж бодож байна.
>
> *- А.Баттулга, Судлаач*

Жендэрийн тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын чуулга уулзалт Дорнод аймагт боллоо

2018 оны 12-р сарын 07—08

Төв, орон нутгийн түнш байгууллагын манлайлагч, мэргэжилтнүүд “Жендэрийн үзэл баримтлалыг төрийн байгууллагын бодлого, төлөвлөлтөд тусгах нь” сэдвийн дор бие биенээсээ туршлага судлаж, хэлэлцэхийн тулд хоёр өдрийн Жендэрийн клубын уулзалт, сургалтанд оролцсон. Энэхүү сургалт, аяллын явцад оролцогчдод жендэрийн тэгш байдлын бодлогын хэрэгжилт, төрийн болон иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны талаарх Дорнод аймгийн шилдэг туршлагатай танилцах боломж олгосноороо онцлогтой.

Уг арга хэмжээний үр дүнд Монгол Улсын, тэр дундаа олборлох салбарын менежментэд оролцож буй төрийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болж, ингэснээр эмэгтэй, эрэгтэй хүмүүс шийдвэр гаргах үйл явцад оролцож, нөөц баялгийг хянаж, нийгэм-эдийн засгийн өсөлтийн үр шимээс хүртэж чадах юм.



Дорнод аймгийн Чойбалсан хотод болсон Жендэрийн тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын чуулганы зохион байгуулагчид, оролцогчид

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нейшнл Таймс Нюсь Тауэр,
3-р давхар

info@merit.mn
www.merit.mn
+976 7016-5000

Global Affairs Canada | Affaires mondiales Canada

МЕРИТ төсөл нь **Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр** болон Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (**CESO**) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (**WUSC**) хоорондын түншлэлээр хэрэгжиж байна.